



Praise and Gratitude

Магтаал ба Талархал

Бурхан минь, сүр бахдал, агуу гайхамшиг, суу билэг, алдар гавьяа, ноёрхол, эрх хэмжээ, цог жавхлан, ивээл хайр, сүр хүч бүхний Эх булаг болсон Тандаа магтаал бүхнээ зориулъя. Та хүссэн хүнээ Хамгаас илүү далаайдаа ойртуулж, хүссэн хүндээ Та Өнө эртний алдар нэрээ таних буяныг хүртээдэг болой. Газар дэлхий хийгээд тэнгэр диваажинд байгаа хэн боловч Таны дээдийн Хүсэл зарлигаас зайлж үл чадна. Өнө эртнээс Та орчлон хорвоогийн хувь тавиланг жолоодож ирсэн, хойшид ч Та хамаг амьтныг ноёрх соор байх болно. Танаас өөр Бурхан үгүй. Та Хамгаас хүчтэн, Хамгийн өргөмжит, Бүхнээс хүчтэй, Бүхнээс мэргэн ухаантай!

Эзэн минь, шадар зарц нарынхаа нүүр царайг Таныг хардаг болгон гийгүүлж, Таны тэнгэрлэг ивээлийн орд руу хандан Таны бие сэктгэхүйн Тодруулал, Таны мөн чанарын Эх булаг болсон Түүнийг танин мэддэг болгон сэктгэл зурхийг нь ариусгаач. Та үнэнхүү бүх хорвоо ертөнцийн Эзэн билээ. Хязгааргүй эрх мэдэлт, Бүхнийг номхотгогч Танаас өөр Бурхан үгүй!

Бахаулла